



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**САНТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД**

2024.08.06 № ГНАГ-2024/13-ШТА-НА-29  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

018020962

холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

### Дүгнэлт

Ардчилсан намын Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сант сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр ( .....<sup>6</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сэлэнгэ аймгийн Сант сумын иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш хариуцлагатай хууль журмыг чандлан мөрддөг сум болон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

Үндэсний өв уламжлал түүх соёлоо дээдлэн 2024 оны ИТХ-ын сонгуульд: “Өрхийн өсөлт иргэний оролцоо тогтвортой хөгжлийн үндэс” хэмээх 5 бүлэг, 17 дэд сэдэв 73 заалт бүхий мөрийн хөтөлбөрийг та бүхэнд танилцуулж байна.

**НЭГ: ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ ЭРХ ЧӨЛӨӨ:**

**1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол:**

1.1.1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг суманд хэрэгжүүлэн ажиллана.

1.1.2. Сургууль цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, хараат бус байх нөхцөлийг бүрдүүлэх талаар арга хэмжээ авч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

1.1.3. Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллана.

**1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ:**

1.2.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулах талаар эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

1.2.2. Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай, чанар хүртэмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.

1.2.3. Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулна.

1.2.4. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллах боломжийг бүрдүүлнэ.

1.2.5. Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.

1.2.6. Мэргэжлийн байгууллагатай хамтран хөнгөлөлттэй эмийн хэрэглээнд хяналт тавьж, эмийн үнийн хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн судалгааг нарийвчлан тогтоож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

**1.3. Хүн амын өсөлт :**

1.3.1. Цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг суманд хэрэгжүүлж, дэмжиж ажиллана.

1.3.2. Суманд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

#### **1.4. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт:**

1.4.1. Суманд гарааны бизнес буюу "СТАРТ-АП"-ыг хөгжүүлэх экосистем /санхүүжилт, сургалт, мэдээлэл/-ийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллана.

1.4.2. Өрхийн үйлдвэрлэл шинээр эрхлэх хүсэлтэй иргэдийн гарааны бизнесийг дэмжих бодлого барьж, хамтран ажиллана.

#### **1.5. Нийгмийн хамгаалал:**

1.5.1. Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн бодлого боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.5.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, оюутан, ажилгүй иргэдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, иргэдэд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах талаар нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллана.

### **ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ:**

#### **2.1. Хямралыг боломж, боломжийг өсөлт:**

2.1.1. Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд сумын үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх талаар тухайн ажил гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллах бодлого боловсруулж, суманд үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээ дэмжин ажиллана.

2.1.2. Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот болон бусад аймгуудад борлуулахад бодлогоор дэмжиж ажиллана.

2.1.3. Малчдын өвөлжилтөд онцгой анхаарч өвс тэжээлийн хомсдолоос сэргийлэн боломжит тэжээлийн нөөцийг бүрдүүлэх санаачилгыг дэмжинэ.

#### **2.2. Өсөлтийн бодлого:**

2.2.1. Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих, дэд бүтэц, бүтээн байгуулалт болон орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих, тогтвортой олон тулгуурт суурийг бий болгоход чиглүүлэх бодлого баримтална.

#### **2.3. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа:**

2.3.1. Жижиг дунд бизнесийн өрөлдөх чадварыг нэмэгдүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулан нээлттэй ажиллана.


2.3.2. Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуйн нэгжүүддээ үйлчлэх, зөвлөх ажиллагааг хэвшүүлнэ.



## **2.4 Төсөв санхүү татварын бодлого:**

2.4.1 Татварын байцаагч, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, зөвлөгөө өгдөг, хууль дээдэлдэг, бизнесийг дэмждэг орчин нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална.

2.4.2. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх бодлого барина.



## **2.5. Хөдөлмөрийн зах зээл:**

2.5.1. Эрдэс баялаг, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого барьж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

2.5.2 Мэргэжилтэй чадварлаг боловсон хүчин, их дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого барьж ажиллана.

## **2.6. Үйлдвэрлэл:**

2.6.1. Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, олон улсын чанар, стандартыг нутагшуулж, экспортлох цогц арга хэмжээ бүхий бодлогыг боловсруулж үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.6.2 Сант суманд хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах "Органик хүнс" хөтөлбөр боловсруулж мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг бүрэн хангаж гадагшаа зах зээлд борлуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

2.6.3 Малаас гарч буй түүхийн эд болон арьс шир, ноос ноолуурыг боловсруулах чиглэлээр үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

2.6.4 Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг олон улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамрагдах боломжийн талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

## **2.7 Дэд бүтэц барилга:**

2.7.1 Эдийн засгийн өсөлтийн суурь болсон хатуу болон зөөлөн дэд бүтэц (Зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл боломжийг идэвхтэй ашиглана.

2.7.2 Авто замын болон аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээний танилцуулга гаргана.

2.7.3 Гудамж нийтийн эзэмшлийн талбай авто замуудыг камержуулна.

2.7.4 Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг барина.

## **3.ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ:**

### **3.1 Орон нутгийн хяналт:**

3.1.1 Сум орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангаж төсөв бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

3.1.2 Орон нутгийн болон төрийн байгууллагын худалдан авалтыг суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг, шалгарсан байгууллагууд тухайн орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

3.1.3 Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх сургалт сурталчилгаа, үзэсгэлэн худалдаа гэх зэрэг төсөл, арга хэмжээг дэмжиж ажиллана.

3.1.4 Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэн, дэмжиж ажиллана.

### **3.2 Шинэ хөдөө хөтөлбөр:**

3.2.1 Уламжлалт мал аж ахуйн гаралтай түүхий эд, ноос ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тордох цэгт бэлтгэн өндөр түвшний технологийн үйлдвэрт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын болон гадаад зах зээл дээр өрсөлдөх үнээр борлуулах боломжийг дэмжиж ажиллана.

3.2.2 Төмс хүнсний ногоо тариалагчдыг хүлэмж зоориор хангах, борлуулалтыг нэмэгдүүлэх асуудлыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

3.2.3 Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, МСҮТ-ийн барилга байгууламжийг сэргээн засварлаж орчин үеийн суурин хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.2.4 Сумын шинэчлэлийг “Шинэ сум” төслийн хүрээнд иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

### **3.3 Бэлчээр ашиглалт:**

3.3.1 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн ААН-ийг бодлогоор дэмжинэ.

3.3.2 Сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагатай болгох, бэлчээрийн ашиглалтын менежментийг сайжруулах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

3.3.3 Малчдын хамтын ажиллагаанд тулгуурлан сумын газар нутгийн 50 орчим хувийг эзэлж буй бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээнэ.

3.3.4 Малчдыг бэлчээр ашиглалтын холбооны зохион байгуулалтад оруулж, гэрээгээр ашиглах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлыг сэргээх бодлого баримтална.

3.3.5 Сумын хэмжээнд ашиглагдаагүй ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож, дэд бүтэц, худаг усны хангамжийг үе шаттай шийдвэрлэнэ.



3.3.6 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар бэлчээр ашиглалтын холбоодод эзэмшүүлэн, хамтарч ажиллана.

3.3.7 Тооноос чанарт шилжүүлэх бэлчээрийн даацыг тохируулж, хамгаалж сайжруулсан малчин өрх, бэлчээр ашиглалтын холбоог дэмжинэ.

#### **3.4 Газар тариалан:**

3.4.1 Газар тариалангийн услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хөгжүүлнэ.

3.4.2 Экспортод чиглэсэн, өндөр ашиг шимт, эрчимжсэн МАА-г газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.

3.4.3 Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлэн ажиллана.

3.4.4 ХААИС-ийн багш эрдэмтэдтэй хамтран мал амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг хэрэгжүүлнэ.

3.4.5 4 улирлын хүлэмжийн аж ахуй, төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг бодлогоор дэмжиж, төв суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор жилийн турш хүртээмжтэй хангах ажлыг зохион байгуулан ажиллана.

#### **3.5 Мал аж ахуй:**

3.5.1 МАА-н салбарыг эдийн засгийн үр ашигтай орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого олох бодлого хэрэгжүүлнэ.

3.5.2 Малыг тооноос чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан МАА-г бодлогоор дэмжинэ.

3.5.3 Шинэ хөдөө хөтөлбөрийн хүрээнд мах, сүү, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.5.4 МАА-н эрүүл бүсийг баталгаажуулж, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээ, хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулан ажиллана.

3.5.5 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малын вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

### **4. ХАРИУЦЛАГАТАЙ САНТ:**

4.1 Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжиж, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх бодлого баримталж ажиллана.

4.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах үйл ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллана.

4.3 Нас хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

4.4 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн бололцоог хангаж, дэмжиж ажиллана.

4.5 Гамшигт байдлын болон хямралт байдлын үеийн зохицуулалтыг хэрэгжүүлж, ухаалаг, үр нөлөөтэй, дэс дараалалтай ажиллах, эрсдэлээс хамгаалах материаллаг баазыг бий болгоно.

4.6 Сумын нутгийн удирдлагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд нэгээс доошгүй хийнэ.

4.7 Иргэд гарын үсэг цуглуулж тодорхой асуудлыг хөндөн дэвшүүлсэн тохиолдолд сумын ИТХ шууд авч хэлэлцэх боломжийг бий болгон ажиллана.

4.8 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай үр дүнтэй хүргэнэ.

4.9 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлүүлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлэн хамтарч ажиллана.

4.10 Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой, ил тод, нээлттэй болгоно.

## **5. ЭКО СИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ:**

5.1 Усны хэрэглээ хяналт хэмжилтийн бодлогыг хэрэгжүүлж, менежментийг сайжруулан тоолуурын системийг нэвтрүүлнэ.

5.2 Бэлчээрийн ургамлыг сэргээх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.

5.3 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.

5.4 Ой, рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, ААН-тэй хамтарч ажиллана.

5.5 Орчноо ногооруулсан үлгэр жишээ иргэд, аж ахуйн нэгжийн оролцоог дэмжиж, жим жимсгэнийн талаар сургалт зохион байгуулна.

## **САНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО**